

13

ХЯТАДЫН БАРУУН БҮС НУТГИЙГ ЭРЧИМТЭЙ
ХӨГЖҮҮЛЭХ АСУУДЛЫН ТУХАЙД

И. Баатар, Ц. Баатар

Хятад улс 1990-2000 онд эдийн засгаа өндөр хурдацтай хөгжүүлж эдийн засгийн шинэ, шинэ нээлттэй чөлөөт бүс нутаг олныг байгуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг тус улсад цутган орох таатай боломж бүрдүүлсээр ирсэн билээ. Одоо Хятад улс эдийн засгийнхаа тогтвортой өсөлтийг цаашид хэвээр хадгалах үүднээс ирэх мянганы эхний арван жил буюу 2010 он гэхэд эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн хүрсэн түвшинг хоёр дахин өсгөх зорилт тавиад байна. Хятадын эдийн засгийн өсөлт жил дараалан 8 хувиас буурахгүй байгаа нь барууны хөгжингүй орнуудын эдийн засгийн өсөлтөөс ч давамгайлах хандлагатай байна. Шинжээчдийн үзэж байгаагаар энэ үзүүлэлт шинэ зууны эхээр ч тогтвортой байх магадлалтай гэнэ. Учир нь тогтвортой хөгжлийнхээ суурь нөхцлийг өнгөрсөн хугацаанд бүрэн хангасан гэж тэд үзэж байгаа юм. Төлөвлөсөн зорилтоо хэрэгжүүлэхийн тулд дотооддоо стратегийн шинжтэй зохицуулах, уялдуулах, адил тэгш хөгжүүлэх зэрэг өргөн цар хүрээтэй, асар их ач холбогдолтой олон чухал ажил өрнүүлж эхлээд байгаагийн нэг нь **“Баруун бүс нутгийг ихээр нээн хөгжүүлэх”** бодлого юм. Сүүлийн үед Хятадын нам төрийн баримт бичиг, хэвлэл мэдээллийн хэрэгсэл энэхүү нэр томъёог байнга өргөн хэрэглэх болсон нь орон даяар энэ ажил хэр зэрэг эрчимтэй өрнөж, улсаас хичнээн их ач холбогдол өгч байгааг тодорхой харуулж буй хэрэг юм.

Хятад улсын эдийн засгийн өсөлт нь хэдийгээр өндөр байгаа боловч эдийн засгийн бүс нутгуудын хөгжил алаг цоог, хөгжлийн түвшин зөрүүтэй хэвээр байна. Тийм ч учраас бүс нутгуудын хөгжлийн түвшинг ойртуулах асуудалтай нягт уялдаа холбоотойгоор дээрх зорилтыг дэвшүүлсэн аж.

Хятад улс төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийг өөрийн онцлог, зах зээлийн чөлөөт эдийн засагтай уялдуулан зоригтой өөрчлөн шинэчилсэн. Өөрчлөлт шинэчлэлтийн явцад өмнөд болон төвийн бүс нутгаа хөгжүүлэхэд ихээхэн туршлага хуримтлуулсан бөгөөд энэхүү туршлага сургамж, эдийн засгийнхаа хүчирхэг нөөц боломжиндоо түшиглэн, гадаадын хөрөнгө оруулалтыг энэ зүгт төвлөрүүлэх замаар тавьсан зорилтоо богино хугацаанд хэрэгжүүлэхээр бүх хүч чадал, нөөц бололцоогоо дайчлан ажиллаж байна.

Баруун бүсэд хамаарах муж, орнууд

БНХАУ байгуулагдсаны дараа нутаг орноо эдийн засгийн бүсүүдэд хувааж бүсчилэн хөгжүүлэх бодлого барьж ирсэн билээ. Хятадын эдийн засгийн баруун бүс нутгийн нэг өвөрмөц онцлог бол гол төлөв хятадын үндэсний цөөнх амьдардаг юм. Шинжаан-Уйгар, Хөхнуур, Өвөрмонгол, Төвд, Нинся-Хотон, Гүйжөү, Гуанси-жуан, Шаньси, Юньнань зэрэг Өөртөө засах орон, муж, хотууд ордог. Эдгээр нь Хятадын хойд, баруун хойд, баруун өмнөд хэсгээр оршдог. Гео-эдийн засгийн хувьд төдийлөн тааламжтай бус. Ихэнхи нутаг нь өндөр уул, говь цөлийн бүсэд хамаарна. Хуурай эрс тэрс уур амьсгалтай, баруун, баруун хойт хэсгийн өндөр уулын бүсэд нүүдлийн мал аж ахуй эрхэлнэ. Нүүрс газрын тос, байгалийн хий, холимог металлын арвин нөөцтэй. Гео-стратегийн хувьд Хятадын маш чухал түшиц газар болно.

Хөгжлийн хувьд Хятадын бусад эдийн засгийн бүсүүдтэй харьцуулахад нэлээд хоцронгуй. Энэ бүсэд хамаарах 12 Өөртөө засах орныг, мужуудын хүн ам тутамд ноогдох ДНБ-ий хэмжээгээр нь харьцуулбал Шинжаан-Уйгар 6229, Өвөр Монгол 5068, Чүнчин 4584, Хөхнуур 4367, Юньнань 4355, Сычуань 4339, Нинся-Хотон 4270, Гуанси-Жуан 4076, Шаньси 3734, Төвд 3716, Ганьсу 3456, Гүйжөү 2342 юань буюу өнөөгийн ханшаар 750-282 ам. долларын хооронд хэлбэлзэж байна. Үүнээс үзэхэд эхэнд яваа нь Шинжаан, Өвөр Монгол, Чүнчин сүүл барьж буй нь Төвд, Ганьсу, Гүйжөү аж. Дээрхи тоо баримтыг Хятад улсын хэмжээний дундаж болох 6392 юаньтай харьцуулахад тус бүс нутаг хаана яваа нь тодорхой харагдаж байна. Хятад улсын хэмжээнд дээрхи үзүүлэлтээр Шанхай хот толгой цохидог. Баруун бүсийн орнуудыг Шанхайтай харьцуулбал, Гүйжөү 12 дахин, Өвөр Монгол 5.4 дахин бага байна.

Баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх бодлого,
түүний учир холбогдол

Хятадын баруун бүс нутгийг ихээр нээн (эрчимтэй) хөгжүүлэх тухай асуудал дөнгөж саяхнаас тавигдаж байгаа асуудал ч бас биш. Энэ асуудал Хятадын эдийн засгийн шинэчлэлтийн эцэг Дэн Сяопины Хятадын эдийн засгийн стратегийн үндсэн үзэл баримтлал болох “Хоёр их тал” хэмээх бүтээлд аль наяд оны үед тусгалаа олчихоод байсан гэж Хятадын өнөөгийн эрх баригчид үздэг.

Хятад улсын дарга Жан Зэминь 1999 оноос баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх асуудлыг улс орны хэмжээний шийдвэрлэвэл зохих томоохон маш чухал тулгамдсан асуудлын нэг гэж үзээд “Баруун бүс нутгийг хөгжүүлэх” гэдэг нэр томъёоны өмнө

талд "ихээр" гэсэн тодотголыг нэмж оруулан хэрэглэх болов. Үүнийг Хятадын төр засгаас энэ асуудалд асар их ач холбогдол өгч байгаагийн нэгэн өвөрмөц илрэл гэж үзэж болох юм. Нөгөө талаар энэ нь Дэн Сяопины стратегийн үзэл санааг амьдралд хэрэгжүүлэх объектив, субъектив тохироо, тааламжтай орчин хятад орны хэмжээнд бүрэлдэн бий болж, улс орны нийгэм-эдийн засгийн өнөөгийн хүрсэн түвшинг цаашид хадгалан хөгжүүлэхэд зайлшгүй хийх ёстой дараагийн шатны алхам, амин чухал эрхэм зорилт болон урган гарч ирсэнтэй холбоотой. Мөн энд үндэстний өөртөө засах орон, муж, хотын хүн амын хүсэл эрмэлзлэл ч нэгэн адил тусгалаа олж байгаа юм. Түүнчлэн хятадын далай тэнгисийн дагуу орших мужуудын уламжлалт аж ахуй, эдийн засгийн хөгжил нь муж, улс орныхоо хэрэгцээг бүрэн хангаад зогсохгүй бие дааж өрсөлдөх чадвартай, экспортын шинэ зах зээлийг нээж, түүнийгээ амжилттай тэлэн өргөтгөж байна. Гэтэл эдийн засгийн баруун бүсийн хөгжил нийт эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэхүйц хэмжээнд буюу зогсонги байдалтай байгаа зэрэг нь олон хүчин зүйлийн улмаас энэ бүс нутгийн хөгжлийг эрчимжүүлэх асуудал Хятадын нам, төрийн бодлогод хурцаар тавигдах болжээ. Энэ бүхнээс гадна эдийн засгийн өнөөгийн хүрсэн түвшинг ойрын 10 жилд 2 дахин өсгөх зорилттой ч нягт уялдаж байгаа юм. Эдийн засгийн өсөлтийн энэ асар их ачааллыг даахуйц түлш, түүхий эд, эрчим хүчний найдвартай эх үүсвэр бий болгох нь өнөөгийн тулгамдсан амин чухал асуудал болоод байна. Хятад улс эдийн засгийн өсөлтөөр дэлхийн бусад орныг ардаа орхиж лут их ололт, гайхамшигтай хөгжил цэцэглэлтэд хүрсэн нь түлш эрчим хүчний эрэлт хэрэгцээг урьд өмнө төсөөлж байгаагүйгээр асар их хэмжээгээр ихэсгэв. Энэ асар их эрэлт хэрэгцээг Хятад улс өөрийн хүчээр хангах асуудал тун хүндрэлтэй гэдэг нь нэгэнт тодорхой болоод байна.

Хятад улс газрын тосны үйлдвэрлэлээр дэлхийд тавд ордог хэдий ч нефтийн үйлдвэрлэлийн хэмжээ нь сүүлийн жилүүдэд өссөнгүй нэг л түвшинд явж ирлээ. Хятад улс 1994 онд ердөө л гуравхан сая тонн түүхий нефть импортолж байсан бол 1996 онд 22.6 сая тонн импортолжээ. 1997 оны эхний гурван улирлын байдлаар газрын тосны импортын хэмжээ 54 хувиар өсч, 24 сая болсон гэж Хятадын газрын тос, байгалийн хийн байгууллагын хэвлэл "Чайна О-Жи-Пи" мэдээлэв. Энэ орны хувьд Хятад улс өөрийнхөө жилийн хэрэгцээний 30 гаруй хувь буюу 50 сая гаруй тонн нефть импортлоод байгаа аж. Ийнхүү газрын тос, байгалийн хийн эрэлт хэрэгцээ тоймгүй их байгаа учир гадаадын орд газруудыг худалдаж авах, олон улсын хил дамжсан олон мянган км урт нефть хийн хоолой барихаар төлөвлөж холбогдох улс орнуудтай гэрээ хэлэлцээр хийж тодорхой тохиролцоонд хүрээд байна. Энэ нүсэр төлөвлөгөөнд Иран, Төв Азийн орнуудаас Казакстанаар дамжуулан Шинжаанаас Шанхай, Сибирээс Хятадын Шандон муж хүртэл нефть хийн хоолой, барим зэрэг шинэ мянганы дуулиант байгууламжууд орж байгаа юм. Баруун бүсийн хөгжилд зориулсан хөрөнгө оруулалтын тодорхой хэсэг ч дээрхи нүсэр төлөвлөгөөг хэрэгжүүлэх урьдчилсан нөхцлийг хангахад чиглэж байна.

БНХАУ-ын Ерөнхий сайд Жү Рүнжи, баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх Хятадын нам, төрийн бодлогын үндсэн чиглэлийг дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Дэд бүтцийн бүтээн байгуулалт

Энэ бол тус бүсийг хөгжүүлэх түлхүүр асуудлын нэг гэж үзсэн. Өргөн уудам газар нутагтай энэ бүсийн зам тээвэр, харилцаа холбооны сүлжээг орчин үеийн эрэлт шаардлагад нийцэхүйцээр шинээр өргөтгөх нь давын өмнө шийдвэрлэвэл зохих тулгамдсан асуудлын нэг болж буй аж. Тийм учраас нэн тэргүүнд улсын хөрөнгө оруултыг энэ салбарт эхний ээлжинд асар их хэмжээгээр оруулж эхлээд байна. Тухайлбал, "Баруун бүсийн байгалийн хийг зүүн бүсэд дамжуулах" улсын хэмжээний нүсэр том төсөл болох Шинжаан-Уйгарын Өөртөө Засах орны Турпаны хотгорт нээсэн байгалийн хийн орд газрын аврин их нөөцийг түшиглэн Шинжаан Шанхайг холбосон 4200км урт хий дамжуулах хоолойн угсаралтын ажил нэгэнт эхлээд байна. Энэ нүсэр байгуулалт нь 8 муж, орон, олон хот тосгоныг дайран өргөрөх юм. Ингэснээр хийн хоолойн дагуух орны эрчим хүчний хангамж, аж ахуй, үйлдвэрлэлийн бүтцэд чанарын дагуух орны эрчим хүчний хангамж, аж ахуй, үйлдвэрлэлийн бүтцэд чанарын хувьсгал, өөрчлөлт гарах төдийгүй ихээхэн хэмжээний хөрөнгийн урсгал эдгээр муж орнуудад цутган орох таатай нөхцөл боломж бүрдэх аж. Хятадын төр засаг дотоод гадаадын хөрөнгө оруулагчид, онцгойлон гадаадын хөрөнгө оруулагчдыг бүтээн байгуулалтын энэ их үйлсэд оролцохыг уриалан дуудаж байна.

Гадаадынхан ямар ч хэлбэрээр хөрөнгө оруулалт хийх бүрэн боломжтой аж. Ямар нэг хязгаарлалт, зохицуулалт байхгүй, аль болох хөхүүлэн дэмжих бодлого баримтлах юм байна. Хийн хоолойн барилга байгууламжийн хэтийн үр өгөөж, ач холбогдол асар их болохыг нотолж гадаад түншүүддээ сайтар ойлгуулж, итгэлийг нь олсноор тэдний хөрөнгө оруулалтыг энэ зүгт чиглүүлж, оруулах хөрөнгийн цар хэмжээг бүр нэмэгдүүлсээр байна.

2. Баруун бүс нутгийн байгаль орчны эвдрэлийг нөхөн сэргээх асуудал

Энэ асуудлыг шийдвэрлэснээр эдийн засгийн баруун бүс нутгийг хөгжүүлэх урьдчилсан таатай нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна. Өнгөрсөн богино хугацаанд Хятад улсын нийгмийн амьдралд гарсан томоохон өөрчлөлт, ололт амжилтын нэг нь тэрбум гаруй хүн ардынхаа хүнсний (амуу буудай) асуудлыг үндсэндээ бүрэн шийдвэрлэсэн явдал юм. Харин ч хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл сүүлийн үед хэрэгцээнээс харьцангуйгаар давж илүүдэл бүтээгдэхүүнээ борлуулах, хадгалах гэж их ажил болж байна. Үр тарианы үйлдвэрлэл хүрэлцээгүй байсан урд өмнөх үед эдийн засгийн баруун бүс нутгийн ой модыг их хэмжээгээр огтлон сүйтгэж, хамаа намаагүй их газар хагалан тариа тарьж байгалийн тэнцвэрийг алдагдуулж байлаа. Одоо үр тарианы үйлдвэрлэл амжилттай хөгжиж, тариачдыг үнэ төлбөргүйгээр тариа будаагаар хангах болсон тул тэдний уулан дээрхи тариалангийн талбайд өвс ургамал, мод тарьж унаган төрхөд нь оруулж байгалийн үзэсгэлэнт сайхан орчин ахуйг бий болгож, гадаадын хөрөнгө оруулагчидын анхаарал сонирхлыг татахуйц таатай орчин нөхцлийг тус бүс нутагт бий болгох чиглэлээр төрөөс тусгайлан анхаарч ихээхэн хэмжээний хөрөнгө гаргаж бүтээн байгуулалтын их ажил өрнүүлж эхлээд байна.

Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх их ажлын өнөөгийн явц

Энэ оны гуравдугаар сард Хятад улсын Төрийн Явдлын Хорооны дэргэд баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх их ажлыг гардан хариуцаж, удирдан зохион байгуулах бие даасан тусгай газар байгуулагдаж ажил хэрэгтээ шамдан орлоо. Хятад улсын хөгжил, төлөвлөлтийн зөвлөлийн дарга бөгөөд Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх газрын дарга Цэн Пэйяны хэлсэнээс үзэхэд энэ жилийн хувьд тус байгууллага дараах 4 үндсэн гол асуудалд анхаарлаа хандуулах аж. Үүнд:

1. Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөг боловсруулж дуусгах
2. Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга, механизмыг судлан тогтоож, шинжлэх ухаан техникийн дэвшлийг өргөн ашиглаж, өндөр мэрэгжлийн чадварлаг боловсон хүчнийг татан оролцуулах, ажиллах хүчнийг сургаж бэлтгэх зэрэг асуудлыг судлан тогтоох.
3. Дэд бүтцийн хөгжлийг түргэтгэх үүднээс баруун бүсэд 10 том барилга байгууламжийг барих ажлыг эхлэхийн дээр дэд бүтцийн хөгжилд нэн шаардлагатай 5 зүйлийн ажлыг дуусгана. Түүнчлэн 31 тэрбум юанийн хөрөнгө оруулсан 5 зүйлийн ажлыг дуусгана. Түүнчлэн 31 тэрбум юанийн хөрөнгө оруулсан 78 томоохон төсөл хэрэгжүүлэх ажлыг эхлүүлэх.
4. Байгаль орчиноо хамгаалах, нөхөн сэргээх, ой хамгаалах ажлыг цаашид эрчимтэй үргэлжлүүлнэ. Тариалангийн газрыг эргүүлэн атаршуулж өвс мод тарих туршилтийн алжыг сайтар зохион байгуулж хэрэгцүүлэх ажлууд орж байна.

"Баруун бүс нутгийг нээн хөгжүүлэх асуудал богинохон хугацаанд хэрэгжүүлчих тийм асар хялбар ажил биш. Хэдэн үеийн хүмүүсийн нэр их хөдөлмөр, хүчин зүтгэл, идэвхи чармайлтын үр дүнд хэрэгжих асар том бүтээн байгуулалт гэдэг нь мэдээжийн хэрэг. Энд юуны өмнө зах зээлийн бүтцийг нарийн судалж тодорхойлон тогтоож, нэгтгэн зангидаж төлөвлөх, түүний шинжлэх ухааны үндэслэлийг нарийн гаргаж, хөрөнгө оруулалтыг санхүүгийн боломж, чадлынхаа хир хэмжээгээр үргэлжлүүлэн хийх болно." гэж Баруун бүс нутгийг хөгжүүлэх газрын дарга Цэн Пэйян энэ ажлын явцын талаар мэдээлэл хийхдээ онцлон тэмдэглэв. Энэ бүхнээс үзэхэд уг ажлын далайц, цар хэмжээ үнэхээр нүсэр том бөгөөд зүйрлэшгүй чухал ач холбогдолтой их бүтээн байгуулалт болох нь тодорхой харагдаж байна.

**Баруун бүсийг эрчимтэй хөгжүүлэх бодлогын хүрээнд
Өвөр Монголд хэрэгжүүлэх ажлын үндсэн чиглэл**

Өнгөрсөн нэгдүгээр сард Төрийн Явдлын Хорооноос эрхлэн баруун бүс нутгийг ихээр нээн хөгжүүлэх асуудлаар зохион байгуулсан хурлаас гаргасан шийдвэрийн дагуу баруун бүсэд хамаарах орон бүр үүрэг зорилтоо тодорхойлж, ажил төрлөө нэгэнт эхэлжээ. Тухайлбал, Өвөр Монголын Өөртөө Засах Орны хувьд гэхэд л тус орны Тэргүүлэгч Юн Булонг (2000 оны 7-р сард галт тэрэгний ослоор амь үрэгдсэн) ажлын хэсгийн даргаар, байнгын дэд тэргүүлэгч Жөү Дэхайг дэд даргаар тус тус томилж, баруун бүсийг хөгжүүлэх төрийн бодлогын хүрээнд Өвөр Монгол хэрхэн хамрагдах

ямар ямар бүтээн байгуулалтанд голлон оролцох, улсын хөрөнгө оруулалтыг хэрхэн үр ашигтай ашиглах талаар стратеги боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг гардан хариуцаж, удирдан зохион байгуулах газрыг төлөвлөгөөний комиссыг түшиглэн байгуулж үйл ажиллагааг нь эхлүүлэв. Энэ байгууллага юуны өмнө Хятад улсын Баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний хүрээнд Өвөр Монгол хэрхэн оролцох үндсэн чиглэлийг тогтоолоо. Үндсэн чиглэлд төрөөс голлон анхаарч буй салбарын хэмжээнд тус өөртөө засах орны өнөөгийн бодит байдал, нөөц боломж, зах зээлийн бүтэц, давуу талаа түшиглэн, дэлхийн эдийн засаг, аж ахуйн хөгжилд нийцүүлэн **"нэг шугам"**, **"гурван орон"**-ыг онцгойлон үзэж, **"арван их инженерчлэл"**-ийг бүх талаар хөгжүүлэн **"гурван их тэмцэх зорилт"**-ыг хичээнгүйлэн хэрэгжүүлж, шинэ давуу талуудыг дахин буй болгож, хөгжлөө түргэтгэж, Өвөр Монголын Өөртөө Засах Орныг XXI зууны Хятад улсын эдийн засгийн хөгжлийн нэгэн шинэ эх үүсгүүр, тулах цэг болгох зорилт тавьж байна. Одоо дээр өгүүлсэн стратегийн нэр томъёонуудад товч тайлбар өгье.

"Нэг шугам" гэдэг нь Өвөр Монгол орныг Хятад улсын умардын амьд орчин ахуйн чухал халхавч шугам болгон бүтээн байгуулна гэсэн үг. Энэ шугам бол Өвөр Монголын нийгэм эдийн засгийг цаашид тогтвортой хөгжүүлэх гол баталгаа болох юм.

Бээжин болон "Гурван умарт"-ын бүс нутгийг элсний нүүдлээс сэргийлэн хамгаалахад чиглэсэн стратегийн чиг шугам юм. Түүнчлэн Хатан гол, Сунгари мөрөн, Ляо хэ голын сав газрыг үер усны аюулаас хамгаалах ажил энэхүү стратегийн амин судас нь болох аж.

"Гурван орон" гэдэг нь Өвөр Монгол Хятад улсын хувьд:

- 1-рт, Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн болон элдэв бохирдолгүй байгалийн цэвэр бүтээгдэхүүний үйлдвэр, аж ахуйг нээн хөгжүүлэх чухал түшиц газар,
- 2-рт, Эрчим хүч, түүхий эд материал, хүнд даацын ачаа тээврийн машин, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, аж ахуйг нээн хөгжүүлэх орон.
- 3-рт, Газрын ховор элементийн эрэл хайгуул, судалгаа шинжилгээ үйлдвэрлэлийг ихээр нээн хөгжүүлэх гол бүс нутаг юм.

"Гурван орон" нь Өвөр монгол нь хөдөө аж ахуй, эрчим хүч, уул уурхай гэсэн гурван салбарын үйлдвэрлэл хөгжүүлэх харьцангуй давуу талтай орон. Энэхүү гурван онцлог, давуу тал нь бүтээн байгуулалтын ажлын бат бэх суурь болох юм. Түүнчлэн энэ нь Өвөр Монголын онцлогтой уялдсан аж ахуй хөгжүүлэх үндсэн чиглэл болно.

"Гурван орон" нь стратегийн бүтээн байгуулалтаар дамжуулан, эрдэс баялгаа нээн ашиглах асуудалд чанарын их хувиралт гарах юм.

Үйлдвэр, аж ахуйн газрын техник технологийг шинэчлэн, мэдлэг боловсролоо дээшлүүлсэний үндсэн дээр Өвөр Монголын Өөртөө засах Орныг Хятад улсын хамгийн цэцэглэн хөгжсөн **"Хүрээлэн буй байгаль орчны бохирдолгүй орон"**, **"Эрчим**

хүчний эх үүсвэрийн бааз газар”, “Газрын ховор элементийн нутаг” буюу гурван чиглэлээр эх улсын түшиж тулах бааз газар болгон бүтээн байгуулахад энэхүү стратегийн бодлого оршино.

“Арван их инженерчлэл” гэдэг нь:

- 1-рт, Амьд орчин ахуйн бүтээн байгуулалтын инженерчлэл
- 2-рт, Авто замын сүлжээний инженерчлэл
- 3-рт, Цэвэр усны нөөцийг илрүүлэн ашиглах, усны алдагдалыг багасгаж арвилан хэмнэх, услалтын системийн инженерчлэл
- 4-рт, Хотын дэд бүтцийн инженерийн шугам сүлжээ,
- 5-рт, Соёл, сургалт хүмүүжлийн бүтээн байгуулалтын ажлын инженерчлэл
- 6-рт, Аж ахуйн бүтцэд зохицуулалт хийж, түүний үйл ажиллагааг шат ахиулан өөрчлөн сайжруулах инженерчлэл
- 7-рт, Амьд организм, биотехнологийн инженерчлэл
- 8-рт, Тал нутгийн аялал жуучлалын дэд бүтцийн инженерчлэл
- 9-рт, Хөдөө тосгонд чинээлэг амьдралыг цогцлон бүтээх инженерчлэл
- 10-рт, Хилийн боомтын бүтээн байгуулалтын инженерчлэл тус тус орно.

“Гурван их зорилт” гэдэг нь уул усаа нөхөн сэргээж, зүлэг мод ургуулж, байгалийн тэнцвэрийг хангана гэсэн үг.

- 1-рт, 2005 он гэхэд хүрээлэн буй амьд байгаль орчны бүтээн байгуулалтын ажилд тодорхой ахиц гаргасан байна.
- 2-рт, 2015 он гэхэд хүрээлэн буй амьд байгаль орчны бүтээн байгуулалтын ажлын үр ашиг ихээхэн дээшилсэн байх болно.
- 3-рт, XXI зууны дунд үе гэхэд байгалийн тэнцвэр алдагдсан нутаг орныг нөхөн сэргээх ажлыг үндсэнд нь дуусгаж байгалын үзэсгэлэнт, тогтвортой хөгжилтэй хил хязгаарын орон болсон байх зорилтыг тус тус дэвшүүлэн тавьж байгаа юм.

Дээрхи зорилтыг хэрэгжүүлснээр Өвөр Монголын Өөртөө Засах Орны үндэстнүүдийн эв нэгдлийг хангаж, улс төрийн хувьд тогтвортой, хил хязгаар нь тайван амгалан, дэвшилтэд нийгэмтэй цөөн тоот үндэстний орон болгон бүтээн байгуулж, үндэстэн бүхэн хамтаар цэцэглэн хөгжиж, улс орноо мандуулж, ард түмнээ баян чинээлэг болгож, 2005 он гэхэд хүн ам тутамд ноогдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг Хятад улсын дунджид ойртуулж, XXI зууны дунд үе гэхэд Өвөр Монгол орныг “Хятад улсын дараачийн зууны эдийн засаг, аж ахуйн амьдралын чухал тулах цэг” болгох зорилт үндсэндээ хэрэгжих юм.

Өвөр Монголд оруулж буй хөрөнгө оруулалтын өнөөгийн байдал

Хятад улсын Нээлтийн Банк Хөх хот дахь салбар банкаараа дамжуулан зөвхөн энэ оны хувьд 150 тэрбум юанийн зээл олгохоор болсон билээ. Үүний 50-60 тэрбум юаныг нь баруун бүсийг нээн хөгжүүлэх төсөл боловсруулахад зориулсан юм. Өнөөгийн байдлаар Хятад улсын Нээлтийн банкны Хөх хотын салбар банкнаас санхүүжүүлэхээр амалсан дөрвөн төсөл бий. Тэрхүү төслүүдийг 892 сая юаниар

санхүүжүүлэх юм. Эдгээрт, Өвөр Монголын 1-р машин механизмын үйлдвэрийн 77 сая юанийн төсөл, Хатан голын усыг Хөх хотод татан оруулах 300 сая юанийн төсөл, тал нутгийн Шин Фа хувь оруулсан бүрэн бус хариуцлагатай компанийн нутаг бэлчээрийн бүтээн байгуулалт болон махны чиглэлийн хонины аж ахуйг хөгжүүлэх төсөл 80 сая юань, Юн Шенүй-гийн 500 клоаттын цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамын 453 сая юанын төсөл орж байна.

Хятад улсын дундаж хөгжилтэй муж, орны тоонд дэвшин орох Өвөр Монголын зорилт

1998 онд Өвөр Монголын дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 хувиар нэмэгдүүлэх зорилт 9.6 хувь болж биелсэн. 1999 онд 8 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьж 7.7 хувь болж биелсэн. 2000 оны хувьд 9 хувиар нэмэгдүүлэх зорилт тавьсан. Энэ нь Хятад улсын дэвшүүлсэн зорилтоос 2 хувиар өндөр байгаа юм. Эдийн засгийг 9 хувиар нэмэгдүүлэх зорилт бол эдийн засаг, нийгмийн хөгжлийн энэ талын шаардлагыг зүйл бүрээр харгалзан үзсний үндсэн дээр дэвшүүлсэн. Өвөр Монголын гадаад дотоод нөхцөл, нөөц боломжийг задлан шинжилж үзвэл дэвшүүлсэн зорилт биелэгддэх бүрэн боломжтой, тийм суурь нөхцөл, таатай орчин нэгэнт бий болсон гэж үзэж болох юм. Дэлхийн эдийн засгийн орчин сайжрах хандлагатай болж, зах зээл, худалдаа улам бүр нэг алхам хөгжиж дэлхийн бараа таваарын зах зээл сэргэх буюу өргөжиж гол нэр төрлийн бараа бүтээгдэхүүний үнэ ханш аажмаар аж ахуйн хөгжилтөнд нааштайгаар нөлөөлөх нь дамжиггүй.

Хятад улсын дотоодын зах зээлийн орчинг авч үзвэл Өвөр Монголын хувьд ч мөн нэгэн адил нэлээд олон нааштай хүчин зүйлүүд ажиглагдаж байна. Үүнд:

- 1-рт, Улсаас дотоодын хэрэгцээг өргөтгөх төрийн бодлогыг тууштай хэрэгжүүлэн, урт хугацаатай улсын зээлийг үргэлжлүүлэн олгож, хөрөнгө оруулалтаа нэмэгдүүлэхээр боллоо. Энэ нь Өвөр Монголын эдийн засаг, аж ахуйн салаа мөчирт хөрөнгө оруулалтын цар хэмжээг өргөтгөх таатай боломж олгож байна.
- 2-рт, Улсаас баруун бүс нутгийг ихээр нээн хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх талаар бодитой алхам хийж гадаадын хөрөнгө оруулалтыг татах, нэн хөнгөлөлттэй төрийн бодлогод түшиглэн, олон улсын зохион байгуулалттай хөнгөлөлттэй зээлийг эрж олоход туслах, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх зэргээр төр засгаас Өвөр Монголын хүрээнд баруун бүсийг нээн хөгжүүлэх төсөлд ихээхэн анхаарал тавьж бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлсээр байна. Энэ бүхэн нь Өвөр Монголын Дэд бүтцийн бүтээн байгуулалтыг түргэтгэх, хүрээлэн буй байгаль орчиныг нөхөн сэргээх, аж ахуйн бүтцийг зохицуулах, шинжлэх ухаан, соёл боловсролыг хөгжүүлэх, өөрчлөлт хийж нээлттэй байх зарчмыг түргэтгэхэд шаардагдах урьдчилсан нөхцлийг хангахад маш чухал түлхэц хүчин зүйл болж байна.
- 3-рт, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн хувьд өнгөрөгч өвлийн зудын их гамшигийн улмаас малын толгойн тоо харьцангуйгаар нэлээд их хорогдсон билээ. Хэрэв энэ жилийн хувьд байгалийн гамшиг тохиолдохгүй бол энэ салбарын үйлдвэрлэлд нааштай өөрчлөлт гарах хандлага байна.

4-рт, 1999 онд Өвөр Монголын аж үйлдвэрийн үйлдвэрлэл нэлээд хурдтай нэмэгдэж жилийн дундаж өсөлт нь 10.4 хувьд хүрлээ. Энэ оны хувьд төрийн өмчийн үйлдвэр, аж ахуйн нэгжид хийж буй шинэчлэлт өөрчлөлтийн хүрээнд "Гурван жилд 2 зорилтыг биелүүлэх" компанит ажлын сүүлчийн жил болох бөгөөд аж ахуйн хүндрэлийг шийдвэрлэх гурван зүйлийн арга хэмжээг нэг алхам урагшлуулж олон тооны төрийн өмчийн аж ахуйг хүнд байдлаас татан гаргах болно. Төр засгийн энэхүү бодлого нь төрийн өмчийн аж ахуйн нэгжийн хөгжлийг түргэтгэх, үр ашгийг нь дээшлүүлэхэд ихээхэн түлхэц болох юм.

5-рт, Ойрын хэдэн жилд Өвөр Монголын нийтийн аж ахуйн үйлчилгээний салбар нэлээд түргэн хөгжиж "9-р таван жилийн" төлөвлөгөөний эхний дөрвөн жилд үйлдвэрлэл нь жил тутам 9.9 хувиар нэмэгдэж ирэв. Энэ оны хувьд энэ салбарын үйлдвэрлэл урьд жилүүдээс нэмэгдэх таатай орчин бүрдсэн юм.

Энэ бүхнээс үзэхэд ӨМӨЗО үйлдвэрлэлийнхээ жилийн дундаж өсөлтийг 9 хувиар нэмэгдүүлэх зорилтоо бүрэн биелүүлж, хөгжлөөрөө Хятад улсын дундаж хөгжилтэй муж орны тоонд дэвшин орох суурь урьдчилсан нөхцөл нэгэнт бүрджээ.

Ашигласан материал:

1. Өвөр Монголын өдрийн сонин, Ардын өдрийн сонины 2000 оны 3 сарын дугаарууд
2. Аян. "Баруун бүс нутгийг эрчимтэй хөгжүүлэх тухай санал, зөвлөмж" Хөх хот, 2000 оны 2-р сар
3. Монгол улсын өдөр тутмын чөлөөт хэвлэл "Өнөөдөр" сонины 1998 оны 3 сарын 27-ны дугаар
4. "Өдрийн сонин"-ы 2000 оны №25.

Танилцуулга

МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль МАРКЕТИНГ, ОЛОН УЛСЫН ХУДАЛДААНЫ ТЭНХИМ

Түүхэн товчоо: Анх Эдийн Засгийн Сургуульд Худалдааны эдийн засгийн тэнхим нэртэйгээр 1959 онд үндэс суурь нь тавигдаж эрхлэгчээр нь дэд эрдэмтэн П.Өлзийбат, Монгол улсын гавъяат багш доктор, профессор А.Дамдин, дэд эрдэмтэн Н.Бүрэн, доктор профессор Д.Дагвадорж нарын эрдэмтэд ажиллаж ирэв.

Анхны төгсөлтөө 1964 онд хийснээс хойших 40 орчим жилд 2000 гаруй эдийн засагч мэргэжилтнүүдийг төгсгөн гаргажээ.

Одоогийн байдлаар мэргэжлийн 6 багш, тэнхмийн туслах ажилтантайгаар сургалт эрдэм шинжилгээний ажил эрхэлж байгаагаас шинжлэх ухааны доктор 1, доктор (Ph.D) 2, докторант багш 2 ажиллаж байна.

Эрхэм зорилго: Зах зээлийн өөрчлөлтөнд уян хатан зохицон ажилладаг олон улсын төвшинд ажиллах чадвартай маркетинг, олон улсын худалдааны мэргэжлийн бакалавр, магистр, доктор бэлтгэх.

Үйл ажиллагаа: Дээрхи зорилгоо биелүүлэхийн тулд маркетингийн болон олон улсын худалдааны мэргэжлүүдээр элсэлт авч бакалавр, магистрын төвшний мэргэжилтнүүд бэлтгэж ирлээ. Түүнчлэн дээрхи чиглэлүүдээр доктор бэлтгэх сургалтыг эхлэн явуулж байна.

Түүнчлэн олон улсын худалдааны менежерээр гадаад орнуудтай хамтарсан сургалт явуулах ажлыг эхэлж БНХАУ-ын Хебейн их сургуульд 30 гаруй оюутныг элсүүлэн 2004 оноос эхлэн Монгол улсад үргэлжлүүлэн сургаж төгсгөх ажлыг эхлээд байна. Өөр бусад улсуудтай ч ийм хэлбэрийн хамтын ажиллагааг хийхээр төлөвлөж байна.

Эдийн засаг, менежментийн сургуулиудын маркетинг, олон улсын худалдааны мэргэжлийн багш нарын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сургалт эрдэм